



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг  
үүргийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Франц Улсын Санте Сюд Төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Эх баригчийн мэдлэг, үр чадварыг бэхжүүлэх төсөл”-ийн олон талт ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүргийг хавсралтаар баталсугай.
2. Тус төслийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 06 дугаар сарын 22-ны А/238 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080225

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 02 сарын 09-ны өдрийн  
4/63 дугаар тушаалын хавсралт

**ЭХ БАРИГЧИЙН УР ЧАДВАРЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН  
ОЛОН ТАЛТ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЧИГ ҮҮРЭГ**

**1. Олон талт ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн ахлагч:	Я.Буянжаргал, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Болормаа, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Б.Энхсайхан, Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Тогтохбаяр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн албаны дарга Д.Мөнхцэцэг, ЭМЯ-ны Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн С.Хишгээ, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх эмч М.Мөнхөө, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ахлах эх баригч Р.Гандиймаа, Архангай аймгийн эрүүл мэндийн газрын дарга Ч.Бадамханд, Амгалан амаржих газрын ахлах эх баригч Д.Уламбаяр, Өргөө амаржих газрын ахлах эх баригч С.Даваасүрэн, Хүрээ амаржих газрын ахлах эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн тэргүүн

П.Цэцэгмаа, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Эх барихын тэнхмийн эрхлэгч

И.Даваадорж, Монголын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын нийгэмлэгийн зөвлөх

Ц.Бөхөө, Санте Сюд ТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газрын төслийн зохицуулагч (зөвшилцсөнөөр)

Б.Цэдмаа, НҮБ-ын Хүн Амын Сангийн эх нярайн зайн оношилгооны төслийн зөвлөх (зөвшилцсөнөөр)

## **2. Олон талт ажлын хэсгийн чиг үүрэг**

2.1 Төслийн үйл ажиллагааг төрөөс баримтлах бодлого чиглэл, хөтөлбөр, бусад төслүүдтэй уялдуулан зохицуулах,

2.2 Эх баригчийн мэргэжил, ур чадварыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичиг, журам, заавартай танилцаж, эх баригчийн ур чадвар, мэргэжлийн тодорхойлолтыг боловсруулан, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн баримт бичигтэй уялдуулан шинэчлэн батлуулахад дэмжлэг үзүүлэх,

2.3 Эх баригчийг бэлтгэх болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрүүдэд зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулж, шинэчлэн батлуулахад дэмжлэг үзүүлэх,

2.4 Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөн, дэмжлэгт удирдлагаар хангаж, ажиллах,

2.5 Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны үр дүнг холбогдох байгууллагуудад мэдээлэх, ил тод байдлыг хангах,

2.6 Дэд ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавих, чиглүүлэх,